

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НУТГИЙН
АВАРГУУД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ


М.БАТ-ЭРДЭНЭ
(Гарын үсэг)

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ОВОО НАМ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


Г.АДЬЯАСҮРЭН
(Гарын үсэг)

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НУТГИЙН АВАРГУУД СУРГУУЛЬД
ХҮНСНИЙ БҮТЭЭГДХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Гэрээний дугаар: ХӨАМСНАСА/20240102002 / (багц-3)

2023 оны 04 дугаар сарын 18 өдөр

Хөвсгөл аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Нутгийн аваргууд ЕБС сургуулийн нягтлан бодогч Н.Нямбаяр (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Овоо нам” ХХК-ийн нягтлан бодогч Оюунчимэг (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 04 дугаар сарын 18-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

57. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

58. Захиалагч нь Хөвсгөл аймгийн Нутгийн аваргууд сургуульд багц-3 (төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ) -г (цаашид “бараа” гэх) 31,673,200 (зучин нэгэн сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуу) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

59. Гэрээний нийт дүн: 31,673,200 төгрөг. Үүнээс: Нутгийн аваргууд сургуульд багц-3 (төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ) нийлүүлэх зардал 2024 онд: 31,673,200 төгрөг;

Нийлүүлэгч нь: Нутгийн аваргууд сургуульд багц-3 (төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ)-ийг 2024 оны 04 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 31 хүртэл нийлүүлнэ.

60. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Тендер ба үнийн хуваарь;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Гэрээний тусгай нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Бусад шаардлагатай баримт бичиг

61. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

62. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

63. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр харилцана.

64. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, түүний хавсралтанд заасан эрх, үүрэг хүлээнэ.

Захиалагчийг төлөөлж:

Талуудын баталгаажуулалт

Гүйцэтгэгчийг төлөөлж:

65. Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, барааны тоо хэмжээнээс бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно.
66. Бараа нийлүүлэх гэрээний явцад хэрэглээний үнийн индекс 5-аас дээш хувиар өөрчлөгдсөн үед холбогдох эрх бүхий байгууллагын тушаал, шийдвэр, чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.3-т заасны дагуу босго үнийг мөрдөж гэрээнд өөрчлөлт оруулах бөгөөд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан талууд баталгаажуулж үйл ажиллагаандаа мөрдөнө.
67. Гэрээг 3 хувь үйлдэж талууд болон холбогдох байгууллагууд тус бүр нэг хувийг хадгална.

ХӨАМСНАСА/20240102002 / (багц-3) ДУГААРТАЙ ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

51. БАРААНЫ НИЙЛҮҮЛЭЛТ БА БАРИМТ БИЧГИЙН БҮРДҮҮЛЭЛТ /МӨРДӨГДӨНӨ/	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
52. ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ /МӨРДӨХГҮЙ/	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг аль буруутай тал барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
53. БАРАА ХҮРГЭХ, ТЭЭВРИЙН БАРИМТ БИЧИГ ИРҮҮЛЭХ /МӨРДӨХГҮЙ/	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог инкотермс (incoterms) буюу парис хот дахь олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
54. БАТАЛГААТ ЗАСВАРЫН ХУГАЦАА /МӨРДӨХГҮЙ/	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна.
55. ГЭРЭЭНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
56. ТӨЛБӨР	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор шуурхай хийнэ.
57. БАРАА НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
58. АЛДАНГИ ОНОГДУУЛАХ	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гтн-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
59. ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ-ГЭЭС ГЭРЭЭГ ЦУЦЛАХ	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. Гэрээ цуцалсан нь нийлүүлэгчийн нийлүүлсэн барааны төлбөрийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.
60. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Захиалагчийг төлөөлж:.....



Талуудын баталгаажуулалт

Гүйцэтгэгчийг төлөөлж:.....



ХӨАМСНАСА/20240102002/ (багц-3) ДУГААРТАЙ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

46. Шалгах болон турших (ГЕН – 1)	46.1. Шалгалт, туршилтыг Нутгийн аваргууд сургууль-ын өмч хамгаалах комисс бараа нийлүүлэх хуваарийн дагуу хүлээлгэж өгөх өдөр хийж гүйцэтгэнэ.
47. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)	47.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд: 26) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь; 27) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт; 28) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; /хүнсний эрүүл ахуйн шинжилгээний бичиг/ 29) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ; /шаардахгүй/ 30) барааны гарал үүслийн гэрчилгээ. Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
48. Баталгаат засвар (ГЕН-5)	50.1. Баталгаат засварын тусгай шаардлага. / Барааны баталгаат засвар 1 жил буюу 365 хоног байна. Чанарын баталгаа гэрээний үнийн дүнгийн 5%-ыг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулна. Баталгаат засварын хугацаанд бараанд ашиглагчаас шалтгаалахгүй гэмтэл, гологдол, эвдрэл гарсан тохиолдолд чанарын баталгааны барьцаа хөрөнгөнөөс үл маргах журмаас гэмтэл, гологдол, эвдрэлийг засуулна. / даган мөрдөхгүй. Чанарын шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэгч цаг тухайд нь солих буюу үнийн дүнг гэрээний үнээр тооцон алданги тооцохгүйгээр төлж барагдуулна.
14. Төлбөр (ГЕН – 7)	52.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд: Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
15. Алданги оногдуулах (ГЕН - 9) ^б	54.1. Алданги оногдуулах хувь: 0,1% Алдангийн нийт дүн: 10%

ХӨАМСНАСА/202301002/ (багц-1) ДУГААРТАЙ ХҮҮХДИЙН ҮДИЙН ХООЛНЫ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны нэр төрөл	Гэрээний үнийн дүн	Нийлүүлэлтын хуваарь	Нийлүүлэлтын хуваарь	Тайлбар
1.	багц-3 (төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ)	36,673,200	2023.04.18-06-07	2024.09.01-12.31	Санхүүжилтийг гүйцэтгэлээр өгнө.

Захиалагчийг төлөөлж:



Талуудын баталгаажуулалт

Гүйцэтгэгчийг төлөөлж:



ХӨАМСНАСА/20240102002/ (багц-3) ДУГААРТАЙ ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦЛИЙН ХАВСРАЛТ

А. Гэрээний үнэ, төлбөр тооцоо

1. Хөрөнгийн эх үүсвэр: **Улсын төсөв**
2. Гэрээний төлбөрийн нийт дүн **36,673,200 (гучин зургаан сая зургаан зуун далан гурван мянга хоёр зуу)** төгрөг байна.
3. **Урьдчилгаа төлбөр олгохгүй.**
14. Санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журмын дагуу захиалагч барааг хүлээн авсаны дараа тухайн сардаа багтааж санхүүжилтийг 100% гүйцэтгэгчид олгоно.
15. Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас шалтгаалаагүй /улс төр, эдийн засаг, валютын ханшны өсөлт, хөрш оргнуудын дайн байлдаан, олон нийтийн хамарсан үймээн самуун, цар тахал, газар хөдлөлт, байгалийн онц ноцтой үзэгдэл ган зуд зэрэг давагдашгүй хүчин зүйл/-ийн нөлөөгөөр нийлүүлж байгаа барааны үнэ өсч гүйцэтгэгч алдагдалд орох тохиолдолд Төр захиргааны байгууллагаас гаргасан тушаал, шийдвэр, чиглэл, Статистикийн үнийн судалгаа, имплицийн түвшинтэй уялдуулан барааны нэгж үнийг зах зээлийн үнэ хүртэл өсгөх арга хэмжээг талууд харилцан тохиролцоно.

Гүйцэтгэгч, захиалагч гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан үүрэг, хариуцлагыг хүлээхээс гадна дараах нөхцлийг хангана. Үүнд:

Нэг. Захиалагчийн эрх, үүрэг

- 1.36. Захиалагч нь тухайн бараа, үйлчилгээг хүлээн авах төслийн менежерийг томилж, нийлүүлэгчийн гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, гэрээ дүгнэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.37. Төслийн менежер зөрчил гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа бараа, үйлчилгээнд зөрчил, гологдол хайх, уг бараанд шалгалт, туршилт явуулах талаарх зааварчилгааг гүйцэтгэгчид өгч, зөрчил гологдол илэрсэн тохиолдолд түүнийг гүйцэтгэгчийн өөрийн зардлаар арилгуулна. Гүйцэтгэгч нь захиалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд төслийн менежер бараа, үйлчилгээ нийлүүлэх ажиллагааг нийтэд буюу хэсэгчилэн зогсоох эрхтэй.
- 1.38. Гүйцэтгэгч нь барааны техникийн тодорхойлолтод заасан шаардлага, стандарт хангаагүй бараа нийлүүлсэн болон гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд, уг зөрчил гологдлыг арилгаж дуусах хүртэл хугацаагаар чанарын баталгааны хугацааг сунгана.
- 1.39. Гүйцэтгэгч зөрчил гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил гологдол арилгахад шаардлагатай зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулах, эсвэл чанарын баталгааны барьцаа хөрөнгөөс татан авч, зөрчил, гологдлыг арилгуулахаар өөр этгээдийг сонгон ажиллуулах эрх эдэлнэ.
- 1.40. Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэлтийн тодотгосон хуваарийг гэрээ байгуулж, баталгаажуулах өдрөөс өмнө төслийн менежерт ирүүлж, төслийн менежерийн саналыг тусган сайжруулах үүрэг хүлээнэ.
- 1.41. Чанарын баталгааны барьцаа хөрөнгийг энэ гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр тухайн бараа, үйлчилгээний чанарын баталгааны хугацааны туршид захиалагчийн тогтоосон дансанд байршуулна. Гүйцэтгэгч бараа үйлчилгээний гологдол, эвдрэлийг арилгасан нөхцөлд захиалагчийн шийдвэрийг үндэслэн чанарын баталгааг чөлөөлнө.
- 1.42. Гэрээ дүгнэсэн тухай акт, бараа, үйлчилгээг хүлээн авсныг нотлох баримт бичиг, гүйцэтгэл тооцсон баримт бичиг зэрэг захиалагчаас шаардсан баримт материалыг гүйцэтгэгчээс захиалагчид ирүүлээгүй нөхцөлд санхүүжилт олгохоос татгалзах бөгөөд баримт бичиг иж бүрдэл хангаагүйн улмаас үүсэх хариуцлагыг захилагч хариуцахгүй

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.31. Гүйцэтгэгч нь барааг үйлдвэрлэх, захиалахаасаа өмнө нийлүүлэхээр санал болгох барааны зураг, техникийн гэрчилгээ /паспорт/, техникийн тодорхойлолт, тохиролын гэрчилгээг захиалагчид ирүүлж, захиалагчаас зөвшөөрөл авсан байна.
- 2.32. Гүйцэтгэгч нь техникийн тодорхойлолт, холбогдох стандартыг хангасан бараа, үйлчилгээг баталсан хуваарийн дагуу захиалагчид хүргэж, төслийн менежерт хүлээлгэн өгнө.

Захиалагчийг төлөөлж:.....




Талуудын баталгаажуулалт


Гүйцэтгэгчийг төлөөлж:.....



- 2.33. Барааг туршиж, шалгах ажиллагааг захиалагчтай хамтран хэрэгжүүлэх ба чанар стандартын шаардлага хангахааргүй гологдол бараа нийлүүлэгдсэн тохиолдолд түүнийг шинэ бараагаар сольж өгнө.
- 2.34. Барааг нийлүүлсний дараа гэрээ дүгнэсэн акт, төлбөрийн нэхэмжлэл, барааны нийлүүлэлтийн гүйцэтгэлийн төсөв, бараа хүлээн авсан тухай акт, барааны тохирлын болон гарал үүслийн гэрчилгээ, техникийн паспорт болон Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтын журамд заасан баримт бичгийг захиалагчид ирүүлж гэрээний төлбөрийг тухайн сардаа багтааж 100% авна.
- 2.35. Хэрэв чанарын буюу баталгаат засварын хугацаанд тухайн бараа ажил, үйлчилгээнд эвдрэл, гологдол гарвал нийлүүлэгч өөрийн зардлаар гологдлыг арилгах үүрэг хүлээнэ.
- 2.36. Бараа, үйлчилгээг хүлээн авах акт, туршилт тохируулгын акт зэрэг баримт бичгийг гараагүй эсхүл уг баримт бичгийг захиалагч хүлээн аваагүй байх хугацааны ашиглалт үйлчилгээний урсгал зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна.

ГЭРЭЭНИЙ НӨХЦЛИЙГ ЗӨВШӨӨРСӨН:

Худалдан авагч:
Хөвсгөл аймгийн Нутгийн-Аваргууд ЕБС
сургуулийн нягтлан бодогч:
Гарын үсэг:  Н.Нямбаяр
Утас: 99389619
Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн сум

Худалдагч:
Хөвсгөл Мөрөн Овоо нам ХХК-ийн
Нягтлан бодогч:
Гарын үсэг:  С.Оюунчимэг
Утас: 88297585
Хаяг: Хөвсгөл аймаг Мөрөн сум

Захиалагчийг төлөөлж: 

Талуудын баталгаажуулалт

Гүйцэтгэгчийг төлөөлж: 

Мөрөн сумын Нутгийн аваргууд ЕБС-ийн 2024 онд хүүхдийн үдийн хоолны материал нүүлүүлэх тендерийн
багц№3 хүнсний ногооны үнийн санал

№	Нэр төрөл	Барааны тодорхойлолт	Гарал үүслийн улс	хэмжих нэгж	тоо ширхэг	EXW нэгж үнэ	нэр төрөл бүрийн EXW бүгд үнэ	Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагд ах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ	Монгол улсын нутаг дэвсгэр дээр бий болсон буюу дотоодын ажиллах хүч, түүхий эд болон бусад үйлчилгээний өртөг	ТӨӨЗ-ны 15.9(а),(2)-д олгосон тохиолдолд төлөх НӨТ болон бусад татвар хураамж	нэр төрөл бүрийн нийт үнэ
1	төмс	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	2550	2000	5100000	255000	100%	НӨАТ-ын тухай хуулинд төмс хүнсний ногоог НӨАТ-аас чөлөөлөхөөр тусгагдсан	5355000
2	байцаа	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	1100	2500	2750000	110000	100%		2860000
3	лууван	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	1210	2500	3025000	121000	100%		3146000
4	сонгино	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	430	3400	1462000	43000	100%		1505000
5	сармис	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	300	900	270000	0	100%		270000
6	хулуу	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	100	10500	1050000	10000	100%		1060000
7	чинжүү	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	80	14900	1192000	8000	100%		1200000
8	өргөст хэмх	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	1000	14900	1490000	10000	100%		1500000
9	помидор	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	100	14900	1490000	10000	100%		1500000
10	брокли	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	100	17900	1790000	10000	100%		1800000
11	салат навч	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	35	17900	626500	3500	100%		630000
12	ягаан байцаа	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	30	3500	105000	3000	100%		108000
13	шар манжин	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	20.1	2500	50250	2010	100%		52260
14	цоо байцаа	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	20	6400	128000	2000	100%		130000
15	буудай	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	20	13900	278000	2000	100%		280000
16	эрдэнэ шиш	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	20	13900	278000	2000	100%		280000
17	яншуй	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	20	12400	248000	2000	100%		250000
18	вандуй	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	20	14900	298000	2000	100%		300000
19	чацарган а	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	150	11900	1785000	15000	100%		1800000
20	аньс	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	100	14900	1490000	10000	100%		1500000

21	нэрс	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	150	19900	2985000	15000	100%	3000000
22	алим	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	150	7900	1185000	15000	100%	1200000
23	гадил	чанарын шаардлага хангасан	МОНГОЛ	кг	150	9900	1485000	15000	100%	1500000
	дүн						30560750	547000		31226260